



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/546

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "г" заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Булган сумын "Минжит Булган" цогцолбор сургуулийн 12-ын "А" ангийн сурагч Н.Маярагүль нарын 15 сурагчдаас ирүүлсэн өргөдөлд дурдагдсан асуудлыг шалган, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Батнасан -Боловсрол, соёл урлагийн газрын математик, мэдээлэл зүйн боловсрол, хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Д.Баасанжав -Цаст Алтай цогцолбор сургуулийн мэдээлэл зүйн багш

Д.Билэгт -Жаргалант сумын 1 дүгээр сургуулийн сургалтын менежер

Ц.Алтаншиг -Мэргэжлийн хяналтын газрын Боловсрол, соёлын хяналтын улсын байцаагч

Нарийн бичгийн дарга

Ц.Балжинням -Боловсрол, соёл урлагийн газрын Физикийн боловсрол хариуцсан мэргэжилтэн

2. Өргөдөлд дурдагдсан асуудлыг хууль, тогтоомжийн дагуу шалган дүгнэлт гаргаж 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч Д.Батнасан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б. ДҮГЭРЖАВ



D/Zax-A/546-Da

02 02702